



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/03

Даланзадгад сум

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 6.1 дүгээр зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь хэсэг, 19.20.1. дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын удирдлагын багийн 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн хурлаар эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаар шийдвэрлэсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан, шинээр олгосон эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Б.Батболд), Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс (Б.Ганшагай), Хяналт шалгалтын хэлтэс (Б.Оюунсүрэн) нарт тус тус даалгасугай.

3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох стандарт дүрэм журмын хүрээнд үзүүлж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.


ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462601006

Эрүүл мэндийн газрын даргын
 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
 А/03 дугаар тушаалын хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа
 эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгасан, тусгай зөвшөөрөл
 шинээр олгосон эрүүл мэндийн байгууллага

Д/д	Байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар	Аж ахуй нэгжийн ТТД	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Хаяг байршил
1. Тусгай зөвшөөрлийг шинээр олгосон					
1	Энэрэл хүний хөгжлийн төв ОНӨААТҮГ Энэрэл сэргээн засах төв СЗТ-26/46/175	3670147	Сэргээн засахын тусламж үйлчилгээ, уламжлалт анагаах ухааны тусламж, сувиллын үйл ажиллагаа	2029 оны 01-сарын 22-ны өдөр хүртэл	Даланзадгад сум 6-р баг Нисэх хороолол "Энэрэл хүний хөгжлийн төв" 2-р блок
2	Тод цагаан оргил ХХК Тод сонор эмнэлэг ЭМХ-25/46/176	3663299	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (чих хамар хоолойн үзлэг оношилгоо)	2029 оны 01-сарын 22-ны өдөр хүртэл	Даланзадгад сум, 8-р баг Нанзад 3 гудамж 304 тоот
3	Гөнгөө жаргалант ХХК Хишиг буян сувилахуйн төв СУХ-26/46/177	3668967	Сувилахуйн дагнасан тусламж үйлчилгээ	2029 оны 01 сарын 22-ны өдөр хүртэл	Даланзадгад сум, 8-р баг Нанзад 3 гудамж 304 тоот
2. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан					
1	Дэлгэрцэций ХХК Дэлгэрцэций эмнэлэг ЭХ-20/14/107	3615359	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (хүүхэд, ахмад настны тусламж үйлчилгээ үзүүлэх)	2031 оны 02 сарын 05-ны өдөр хүртэл	Цогтцэций сум Өгөөмөр баг Борын 1-110
2	Эмт өвс фарм ХХК Эмт өвс эмийн сан ЭСХ-20/14/109	3636755	хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх	2031 оны 02 сарын 05-ны өдөр хүртэл	Даланзадгад сум 6-р баг Цогжавхлан-2 супермаркетын байр